



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/265

Ховд


Цэргийн албыг мөнгөн төлбөрийн
хэлбэрээр орлуулан хаалгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.4, 31.5, 31.5.1, 31.5.2, 31.6 дахь заалт, 2021 оны 02 дугаар сарын 17-ны 41 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар "Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай" тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс чөлөөлөгдсөн иргэдийн нэрсийг хоёрдугаар, 2022 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Мөнгөн төлбөр төлөхөөр шийдвэрлэсэн цэргийн үүрэгтний тогтоосон мөнгийг цэргийн дүйцүүлэх алба, төрийн сангийн 100160000983 дансанд 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор төлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа Б.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

5. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэлийг хөтлөх, төлбөрийн хэмжээ тогтоох, хураан авах, зохих дансанд байршуулах, зарцуулалтыг тайлагнах, мөнгөн төлбөрөө төлөөгүй цэргийн албанаас зайлсхийгчдийн асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх зэрэг ажиллагааг зохих хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа Б.Ганхуяг)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1349